

**«ЭДҮГЭЭГИЙН АЗИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ»
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ-УЛС ТӨРИЙН БАГА ХУРАЛ**

1962 оны 6-р сарын 30-наас 7-р сарын 2 хүртэл. Москва хотноо «Эдүгээгийн Азийн тулгамдсан асуудал» сэдвээр олон улсын эрдэм шинжилгээ-улс төрийн бага хурал болов. Тус бага хуралд ЗХУ, Монгол, Вьетнам, Лаос, Кампучи, Афганистан, Энэтхэг Бангладеш Шри-Ланка Сири филиппин, Турк, Марокко зэрэг Ази африкийн 20 гаруй орон Палестины чөлөөлөх хөдөлгөөнийг болон Ази Африкийн улс түмний эв санааны нэгдлийн байгууллагыг төлөөлсөн улс төр, олон нийтийн томоохон зүтгэлтнүүд, нэрт эрдэмтэд оролцов.

Бага хуралд ЗСБНХУ-ын ШУА-ийн дорнодахины судлалын хүрээлэнгийн захирал, академич Е. М. Примаков, Вьетнамын эрдэмтэн Нгуен Кхань Тоан, Сирийн профессор Ф. Р. аль-Ансари, Монголын академич Ш.Нацагдорж, Ш. Дира нарын зэрэг олон эрдэмтэд илтгэл тавьж Азийн орнуудын энх тайван, аюулгүй байдал, хамтын ажиллагааг бэхжүүлэх тухай асуудал хэлэлцэж, тус тивийн улс түмний нийгэм-эдийн засгийн хөгжлийн үндсэн зорилтуудын талаар санал солилцов.

Хуралд оролцогсод Ази, Номхон далайн районы улс орнуудын хоорондын харилцан үл довтлох, хүч үл хэрэглэх тухай Конвенц байгуулах талаар манай улсын дэвшүүлсэн саналыг бүрэн дэмжив.

Бага хурлын үйл ажиллагаа нь хуралд оролцогсод империализм, жанжлалын эсрэг, Азийн аюулгүй байдал, улс түмний энх тайвны асуудлын талаар санал нэгтэй байгааг дахин харуулав. Энэ нь бага хурлаас батлан гаргасан уриалга, мэдэгдэл зэрэг баримт бичгүүдэд тодорхой тусгалаа олсон юм.

Улс орнуудын төлөөлөгчид ингэж уулзаж Азийн улс түмний энх тайван, аюулгүй байдал хамтын ажиллагааны асуудлаар санал солилцох явдал үр дүнтэй болохыг харгалзан цаашид ийм бага хурал үе үе зохиож байхын тул төлөөлөгчид санаачлагын группийг 5 гишүүнтэйгээр байгуулсан болно.

Н. Ишжамц

**БНСВУ-Д БОЛСОН АЗИЙН СОЦИАЛИСТ ТАВАН
ОРНЫ НАЙРАМДЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН УУЛЗАЛТ**

1982 оны 8-р сарын 9-ний өдөр БНСВУ-ын нийслэл Ханой хотод Вьетнам, ЗХУ, Монгол, Лаос, Кампучийн найрамдлын нийгэмлэгүүдийн төлөөлөгчдийн уулзалт болов.

Тус уулзалт дээр Вьетнамын нийгмийн Шинжлэх ухааны Хорооны дарга Нгуен Кхань Тоан, Зөвлөлтийн эрдэмтэн А. А. Мурадян, Лао-

сын соёлын яамны орлогч сайд Үнхэан Фүнсават, Кампүчи-зөвлөлтийн найрамдлын нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн дарга Мөнхүн, Монголын төлөөлөгч Н. Ишжамц нарын зэрэг нөхөд илтгэл тавьж, Энэтхэг-Хятад, Зүүн Өмнөд Азийн улс түмний аюулгүй байдал, энх тайван түүнд жанжлах үзэлтний зүгээс Америкийн империализмтэй сүлбэлдэн түрэмгийлж байгаа аюул заналын тухай санал солилцов.

Уулзалтанд оролцогсод америкийн империализм жанжлах үзэлтэн нарын дайнч түрэмгий үйл ажиллагаа, социалист Вьетнамын эсрэг үйлдсэн маогийнхны зэвсэгт довтолгооныг эрс эсэргүүцэн буруушааж, аюулгүй байдал энх тайвныг сахин хамгаалах нь нийт улс түмний эн тэргүүний зорилт мөн гэж цохон тэмдэглэж байв.

Түүнчлэн Ази, Номхон далайн орнуудын аюулгүй байдлыг бэхжүүлэх тухай манай улсын дэвшүүлсэн саналыг төлөөлөгчид санал нэгтэй дэмжив.

Тус уулзалт нь улс түмний аюулгүй байдал, энх тайвныг сахин хамгаалах асуудлын тухай чухал албан мэдээ батлан гаргаад Ливан Палестиний эсрэг Израилийн эрх баригчдын үйлдэж байгаа цуст түрэмгийллийг эрс эсэргүүцэн буруушааж, арабын улс түмний эх оронч шударга тэмцлийг идэвхтэй дэмжиж байгаагаа илэрхийлсэн цахилгаан утсыг палестины чөлөөлөх байгууллагын нэр дээр явуулав.

Н. Ишжамц